

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Даваажав	Дугаар	L138
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Баруун- Урт
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Эрдэнэмандал хийдийн хамба лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Мандалын хүрээ	Сүм хийдийн дугаар	СБХЛ 041
Одоогийн сүм хийд	Эрдэнэмандал хийд	Сүм хийдийн дугаар	СБХЛ 040
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Халзан Мандалын хүрээ

Эрдэнэмандал хэмээх Пунцагчойнхорлин буюу хотол чуулгант номын хүрдэн хийд нь Халхын Сэцэн хан аймгийн Гадин засгийн хошуу сүүлдээ Ёст бэйс Доозавын хошуу, Эдүгээгийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Баруун-Урт сумын зааг нутаг болох Эрдэнэмандал гэдэг газар 200 жилийн өмнө байгуулагдсан гэдэг. Богд эзний мутрын үсэгтэй, алтан үсэгтэй, есөн хутагтай энэ хийд нь 1000 гаруй ламын данстай, байнга мянган лам шавилан сууж хурал номоо хурдаг, дөрвөн аймаг, 12 дацантай , эзэн хаандаа мэдээтэй, чийга ямпайтай 2 өндөр баганатай, олон олон сайхан өндөр суваргатай, ар халхын үрд зүгийн томоохон уран хийц бүхий хийдүүдийн нэгэн байжээ. Хамбай, сангай, Шүтээн, Эмчийн гэсэн 4 аймагтай, Цогчин, Чойр Жүд, Дүйнхор, Мамба, Хайлан, Майдар, Ганжуур, Авид Ламрингийн дуган, чойрын гонхон сүм, Гол сахиусны гонхон сүмтэй байв.

Энэ хийд нь 5 ботийг үзэж дуусган, дом тавьж, гэвш, гавж аграмба маарамбын дамжаа бариулж, Чойроос гэвш, гавж, Жүдээс аграмба, Манбаас маарамба зэрэг тухайн үеийн төрөл бүрийн номч мэргэн эрдэмтэн сэхээтнийг төрүүлэн гаргадаг эрдмийн гол төв байжээ.

Тухайн үед энэ хийдээс төрөн гарсан Аграмба Гандингийн Цэрэндорж 3 сав ертөнцийн номыг үзэж мэдсэн хүн байсан гэдэг. Их хүрээнд номоороо гайхагдаж байсан Данзанранжамба, Даваа хувилгаан, Хар нүдэн Содов, майга Шаравжамц, Дүнгийн Дамбий, Мөндий Гомбын Лала Жамбал, Чүлтэм даа лам, Наваан ловон, Балдан ловон, Наваан гэлэн, гавж

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

чалчаахай Балдан, Жунжаа Дуламсүрэн, Түвдэн Гэцэл, Сайчиг гавж, Овоохой Лосол, гавж Данх Даваг, гавж Гандандонойн жунай, Үжгэр Жунай, Жаал Ранжил, Жамбаажамц нарын зэрэг сайн номтой лам олныг дурдаж болно. Мөн энэ хийд 100 гаруй гавж, агарамба, маарамбатай байжээ, бусад хийдийн нэгэн адил номын хэрэгсэл, төрөл бүрийн цамын хувцас, бурхад 9 эрдэнээр бүтээсэн судрууд, Ганжуур, Данжуурын бүрэн боть, алт мөнгөөр бүтээсэн судар номууд, шар зурхайн судрууд, цул алтан бурхад, зулын алт мөнгөн цөгц, уран хийцтэй олон сайхан суварга, номын бар, барлах хэрэгслүүд, шашны хөгжмийн зэмсгүүд цөм бүрэн байжээ.

Эрдэнэмандал хийдийн домог

Одоогоос 20 гаруй жилийн өмнө Эрдэнэ өвгөн, Мандал чавганцтай амьдарч байсан гэдэг. Хэдэн цагаан ямаатай түүнийхээ сүү саалийг хэрэглэдэг байжээ. Гэтэл Гандин засгийн хошууны ноён эзэн хааны зарлигыг биелүүлэхэд хийд байгуулах гэж газар усыг шинжихээр тусгай шинжээч хэсэг хүмүүсийг илгээжээ. Тэдгээр хүмүүс хоёр хөгшиний гадаа ирж буугаад мэнд усаа мэдэлцээд өвгөн эмгэн хоёрын нэрийг асуухад нэр алдраа хэлсэнд тэдний нэрийг сонсоод ихээхэн билэгшээжээ. Тэдгээр өвгөн эмгэн хоёрын гэрийн хойно байгаа овоог Эрдэнэмандал хэмээн нэрийдэж овооны энгэр дээр түмэн гэлэн байнга байх ийм эрдэм номтой нутагт хуварга төрж байх газар гэж шинжээч нар шинжиж хийд байгуулахаар болж байтал цагаан сахалтай өвгөн бадарчин лам нэгэн өглөө өвгөн эмгэн хоёрын гэрийн баруунтаа жодгороо босгоод номоо айлдаж байв. Хоёр хөгшин ч их билэгшээж өглөөний цайныхаа дээжийг бадар аяганд нь хийж бариад цамаан ямааны сүүгээр тараг бүрж ламд зооглуулжээ. Гэтэл тэр өвгөн лам ихэд таашаан өвгөн эмгэн хоёрт сахиус, бурхан, үрэл рашаан тэргүүтнийг хүртээж ном айлджээ. Чавганц нь маргааш өглөө нь тахилаа өргөхөөр гарахад нь өвгөн лам, жотгор нь байхгүй байжээ. Баруун хойшоо хартал агаарт өвгөн лам эвхсэн жодгор дээрээ суугаад нисэхээр хөөрч байхыг үзээд өвгөнөө дуудаад гайхацгаасан гэдэг. Жодгор шаасан гадасны дөрвөн нүх онгойж хэвээрээ байсанд Чойр дуганы дөрвөн баганыг тэр нүхэнд нь барьсан домогтой. Учир нь хэмэвээс Бурхан багш өөрөө морилон ирж, номоо айлдан гэзрыг нь аравнайж дуганы шавийг тавьсан юм гэнэ билээ. Эрдэнэмандал хийдээс эрдэмтэн номч мэргэд төрдөг нь энэ домогтой холбоотой ажгуу. өвгөн эмгэн хоёрт хайрлаж өгсөн Гомбо бурхан хэзээ хойно хүртэл тус хийдэд хадагалагдаж байсан гэдэг.

Энэ хийд халхын Цэцэн хан аймгийн Гандин засгийн хошууны “Эрдэнэмандал” гэдэг газар 20 гаруй жилийн өмнө байгуулагджээ. 700 гаруй лам нар байнга шавилан сууж хурал ном хурдаг 4 аймаг, 12 дацантай, эзэн хаанд мэдээтэй Чийг /эзэн хааны морины уяа/ ямбай /эмээлийн тавиур/ гэсэн хоёр өндөр баганатай, шавар дөрвөлжин байртай, олон сайхан суваргатай, ар халхын үрд зүгийн томоохон хийдийн нэг байжээ.

Хамбай, Сангай, шүтээн эмчийн гэсэн дөрвөн аймаг, цогчин, чойр, дүнхэр, мамба, хайлан, майдар, ганжуур, авид, ламирамбын дугана, чойрын гонхон сүм, гол сахиусны гонхонтой байжээ. Энэ хийд нь 5 ботийг үзэж дуусган дом тавьж, гавьж аграмбын дамжаа бариулж, чойроос гавьж, жүдээс агарамба төрж тухайн үеийн гүн ухааны гайхамшигт төрөл бүрийн эрдэмтэн мэргэдийг төрүүлэн гаргадаг байжээ. Энэ хийдээс төрсөн эрдэмтэн аграмба Гадингийн Цэрэндорж тухайн үед эрдэм номоороо гайхандаж байсан лүнгийн багш агарамба Ядамсүрэн, зурхайч багш Шаравсамбуу, зурхайч Жовоо Чүлтэм, Шомбогор Чүтэм, Балдан, Наваан ловон, хануурч эмч зөгий Дамбий, алдат бариа засалч Наваан гэлэн, маарамба эмч Түвдэнгацал, Лаала Жамбал, зураач Шарав нарыг дурдахад хангалттай. Энэ хийд орон нутагтаа хамгийн том байсан бөгөөд лам нар нь эрдэм номоороо аль ч хүрээ хийдэд очиход гайхагдаж, тэр хийдээс олон сайчууд, лам нар өөр хүрээ хийдэд уригдан залагдаж уншлага айлтгал хийдэг байжээ. Намрын эхэн сард гурван өдөр цам цамнаж, наадам хийдэг байжээ. Намрын эхэн сарын 27-нд торгон, 28-нд майдар,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

29-нд их цам хийж нааддаг байв. Бусад хийдүүдэд нэгэн адил шашны хурал номын хэрэглэл, төрөл бүрийн бурхад, есөн эрдэнэ, алт мөнгөөр бичсэн судар номууд, алтан бурхан, мөнгөн цөгцнүүд, ном хэвлэх, үйлдвэрлэх, олшруулах, барлах, хэрэгслүүд цөм бүрэн байжээ. Эдгээрийг хийдийг тарах үеэр нутгийн ард түмний ил далд нуун хадгалж байгаа нэлээд ховор зүйлс одоо ч байсаар байна. 200-аад жилийн өмнө Гадин засгийн хошууны ээлтийн Гомбодорж залж ирж шүтсэн хийдийн гол сахиус амилсан Гомбо бурхныг хийд тарах үеэр гэвш Бумуу хэмээх Шарав хүрээнд аваачиж хайрлаж хадаглаж хамгаалснаар охиныхоо хүү Загдсамбарын Нүрээдэд /ҮДН-н тэргүүлэгч/ захиж үлдээсэн байна. тэрээр энэ жил орон нутагтаа ирэхдээ хийдээ сэргээвэл амилсан бурхан Гомбыг өгье гэж мэдэгджээ. Мөн тэр хийдийн чойрын гол шүтээн “ Чойрын цэндэм” гэдэг дэлгэмэл зурмал бурханыг хийд тарах үеэр авч хадаглаж байгаа. Хийдэд сууж байсан гэвш Ходой хэмээх Намжилд / нисгэгч Жамсрангийн аав/ байгааг тэр хийдэд сууж байсан нутгийн олон өвгөд хуучилсан юм.

Эрдэнэ өвгөн Мандал чавганц хоёр хэдэн хонь ямаатай ганц гэрээрээ амьдарч байжээ. Гэтэл нэгэн өдөр өндөр настан өвгөн бадарчин эрдэмт лам ирээд гурван гадастай жодгороо гадаа нь барьж хоногложээ. өглөө эрт өвгөн хөгшин хоёр идээ цайныхаа дээжийг өвгөн эрдэмтэн ламд барьжээ. Тун удалгүй Мандал хөгшин гарч харахад жодгор, эрдэмтэн лам ч алаг байжээ. Ийм хурдан зайнд алга болсон байсныг гайхан харвал баруун хойд уулын баруун мөрөн дээгүүр нисэж яваа харагджээ. Энэ сонин юмыг нүдээрээ үзсэн Мандал чавганц Эрдэнэ өвгөн хоёр маш их гайхаж байн байн хуучилдаг байсан гэнэ. Үүнийг нэгэн мэргэн бадарчин үзээд будда ирж гэж үзжээ. Ингэж энэ бурхан ирж хоноглосон газар Эрдэнэмандал нэртэй хийдийг Гандин засгийн хошуунд байгуулсан түүхтэй. Тэр ч байтугай бурхан багшийн жодгороо барьж хоноглосон газар Чойр сүмээ барьсан юм гэнэ билээ. Энэ хийдийг байгуулж гол шүтээнээ залахаар гандин засгийн Ээлийн Гомбодорж гэдэг хүн Бээжин орсон юм байх. Ямар бурхан залахаа сайн товлоогүй гайхалцан явж Бээжин ойртож байхад сайхан хар морьтой хүн ирж мэнд усаа солилцож нэрийг нь асуувал Гомбо гэдэг гэжээ. Энэ хүний нэрээс санаа авч Гомбо шүтээн залахаар болцгоов. Бээжин хотод ирж Хятадуудын бурхад бүтээдэг том том пүүсүүдээр явж нэгэн пүүсээс бурхан авахаар тохиролцоод пүүсийн эзэн данжаад нь бурхан хийлцдэг нэгэн хүнээ дагуулж ороод авахыг зөвшөөрчээ. Тэр хүнд цагаан идээ болон бага зэргийн идээ бэлэглэхэд маш их баярлаж энэ бурхныг аваа. Эрхий хурууг нь залгахад “Ёо” гэж дуугарсан бишүү. Энэ бол жинхэнэ амилсан бурхан хэмээн хэлээд аваад өгчээ. Тэр бурхнаа аваад пүүсийн эзэн данжаадын дэргэд ирэхэд данжаад толгойгоо салаавчлан “Хай яанаа” гэж уулга алдан дурамжхан байж өгсөн гэж бурхан залж ирсэн хүмүүс хуувчилдаг байсан гэнэ. Тэр авчирсан шүтээнээ гол шүтээн болгон тахиж шүтэж байгаад 1930-аад онд хийдийг эвдэж сүйтгэхэд хийдийн сахиусных нь гонх ганцаар үлдээд байхад та нар хүрч эвдэж чадахгүй байгаа бол би залаад авлаа гээд авсан тэр хийдийн гэвш Бумуу хэмээх Шарав Улаанбаатар хотод залж аваачиж хадгалсаар өөрийн охины хүү З.Нүрээдэд захиж үлдээсэн учиртай гэнэ.